

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар сарын 02-ний өдөр

дугаар 01

Дархан –Уул аймаг

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 заалт, Дархан Нэхий Хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.3 заалтыг тус тус удирдлага болгон Дархан Нэхий ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаж, ТУЗ-ээс компанийн үйл ажиллагаанд өгсөн дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр гаргасан 2024 оны 03 дугаар сарын 02- ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн нэг дэхь заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хавсралтыг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Э. БАТСАЙХАН

“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 дугаар сарын 02-ний өдөр

дугаар 02

Дархан –Уул аймаг

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
гишүүдийг сонгож, батлах тухай

Компанийн тухай хуулийн 62.1.7, 77.1, 77.3, 77.4 заалтууд, Компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.23, мөн 7.10 заалтыг удирдлага болгон 2024 оын 03-р сарын 02-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг дуусгавар болгосугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг доорхи бүрэлдэхүүнээр шинэчлэн сонгож, баталсугай.

Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр:

Эрдэнэдалай овогтой Батсайхан

Равжаа овогтой Сүмбэнхүү

Батсайхан овогтой Мягмар-Өлзий

Баасан овогтой Гэрэлмаа нарыг,

Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээр:

Далхжав овогтой Батжаргал

Хумбагай овогтой Золжаргал

Цоодолсүрэн овогтой Хадаа

Баатар овогтой Бурмаа

Ринчин овогтой Бямбадорж


нарыг тус тус сонгосугай.

3. Хууль тогтоомж, компанийн дүрэм, засаглалын журмуудыг мөрдөж ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдэд үүрэг болгосугай.
4. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн бүрэлдэхүүний талаар олон нийтэд мэдээлж, шинээр сонгогдсон гишүүдийн талаарх мэдээллийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргүүлэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /Х.Нарантуяа/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Э. БАТСАЙХАН



“ДАРХАН НЭХИЙ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 03 дугаар сарын 02-ний өдөр

дугаар 03

Дархан –Уул аймаг

Төлөөлөн удирдах зөвлөлийн
гишүүдийн цалин, урамшуулал,
үйл ажиллагааны төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 заалт, Дархан Нэхий Хувьцаат компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 заалт, тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2024 оын 03-р сарын 02-ний өдрийн ээлжит хурлын тооллогын комиссын 02 тоот шийдвэрийн хоёр дахь заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дархан Нэхий Хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшуулал, үйл ажиллагааны төсвийг хавсралтаар баталсугай.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн төсөвт зардлыг санхүүжүүлэхийг ДНХК-ийн гүйцэтгэх захирал /Б.Гэрэлмаа/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Э. БАТСАЙХАН